



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/40

Эмээлтолгой

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 31 дүгээр зүйлийн 31.4, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 10/04 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн нэгдсэн системд оруулсан төлөвлөгөөний дагуу халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулж, малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийн, гүйцэтгэлийг малчны хотноос "Мал эмнэлгийн нэгдсэн систем"-д оруулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсанаас хойш 28 хоногийн дотор тухайн малчны хотноос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдэд хориглосугай.

3. Дээрх ажлыг мэргэжил, арга зүй, заавар зөвлөмжөөр ханган, ажлын явцад байнгын хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлэн ажлын хэрэгжилт, үр дүнг сумын Удирдлагын зөвлөлд танилцуулж, дүн мэдээг 2023 оны 11 дүгээр сарын эхний 10 хоногт багтаан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХЖАРГАЛ

642301015